



ИРГЭНИЙ НИСЭХИЙН
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2016 оны 10 сарын 18 өдөр

Дугаар A/688

Улаанбаатар хот


Давхар эрхэлж болох ажлын
жагсаалт батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай Монгол Улсын хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2.6 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Хууль болон Засгийн газраас зөвшөөрсөн давхар эрхэлж болох ажлын жагсаалтыг хавсралтаар баталсугай.


2. Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, ажиллахыг Захиргаа, удирдлагын газар /Т.Батжаргал/, Хууль, эрх зүйн газар /З.Туяа/-т тус тус үүрэг болгосугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ



Л.БЯМБАСҮРЭН

Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын
2016 оны 10 дугаар сарын 18 ны өдрийн А/688
дугаар тушаалын хавсралт



Давхар эрхэлж болох ажлын жагсаалт

1. Хууль тогтоомж, олон улсын гэрээгээр болон Засгийн газраас баталсан журмаар зөвшөөрсөн ажил;
2. Багшлах, эрдэм шинжилгээний болон бүтээлч ажил;
3. Татварын албанд ажил, үйлчилгээ хувиараа эрхэлж байгаа гэж бүртгүүлсэн, жилийн орлого нь 1 сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 80 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөс илүүгүй, эсхүл төмс, хүнсний ногооны тариалан болон ойн аж ахуй, зөгий, загас, амьтан үржүүлэг, сургалт-аялал, сургалтын бусад үйл ажиллагаанаас орлого олдог;
4. Ашиг сонирхлын зерчил үүсэхээргүй бол өөрийн удирдах албан тушаалтан, эрх бүхий байгууллагын бичгээр өгсөн зөвшөөрлийн үндсэн дээр бусад алба, гэрээний ажил, үүрэг /дүрэм, стандарт гэрээгээр боловсруулах/;